

Сургуультай холбоотой санал, гомдол гаргах тухай

Бид аливаа санал, гомдлыг шуурхай шийдвэрлэхийг хичээж ажилладаг тул та өөрт тулгарсан асуудлаа аль болох эрт бидэнд мэдэгдэх хэрэгтэй.

Зарим тохиолдолд сургуулийн захиралтай ярилцах нь илүү тохиромжтой байж болно. Хэрвээ та санал, гомдлоо хэнд мэдэгдэхээ мэдэхгүй байвал таны хүүхдийн багш эсвэл сургуулийн оффисын ажилтан танд холбоо барих зөв мэдээллийг өгөх болно.



Асуудлыг гаргаж тавих нь түүнийг шийдвэрлэж эхлэх хамгийн зөв зам юм.

Хүүхдийнхээ ангийн багш, сургуулийн оффисын ажилтан эсвэл ахлах сургууль бол тухайн анги бүлгийн зөвлөхтэй холбоо барьж эхлээрэй. Та санал, гомдлоо биеэр ирэх, имейлээр, утсаар эсвэл хэрвээ хүсвэл захиагаар ч илэрхийлж болно. Ангийн багштай уулзах цаг гаргах эсвэл сургууль руу залган, цаг товлоорой.



Санал, гомдлоо бичгээр илэрхийлэхийг бид таниас зарим тохиолдолд хүсч болно. Тодорхой мэдээллийг дурдан, санал гомдол гаргаснаар та ямар үр дүн хүсч байгаагаа бидэнд мэдэгдээрэй.

Бичгээр санал, гомдол гаргахад бид танд туслах боломжтой. Мөн та санал, гомдлын маягт эсвэл Feedback Assist widget-г ашиглаж болох ба эдгээрийг Боловсролын Яамны вэб хуудаснаас авах боломжтой. Ангийн багштай уулзах цаг гаргах эсвэл сургууль руу залган, цаг товлоорой.



Ихэнх тохиолдолд ирсэн санал, гомдлыг ажилтнууд өөрсдөө шийдвэрлэх боломжтой байдаг. Зарим санал гомдлыг шийдвэрлэхэд сургуулийн захирал эсвэл ажлын байрны менежер оролцох шаардлагатай болдог.

Санал, гомдол шийдвэрлэдэг хүн нь тухайн асуудалд оновчтой үнэлгээ хийн, цаашид зөв шийдвэр гаргахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах хэрэгтэй байдаг. Санал, гомдлын менежер тантай холбогдохоосоо өмнө судалгаа хийж болно.

Аливаа санал, гомдолд хариу арга хэмжээ авахдаа бид дараах зүйлсийн аль нэг эсвэл хэд хэдэн алхмыг хийж болно. Үүнд:

- Асуудлыг залруулах эсвэл нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээ авах
- Уучлалт хүсэх
- Тайлбар хийх
- Тухайн нөхцөл байдалд илүү дээр эсвэл өөр байдлаар арга хэмжээ авах боломжтой байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Таны гаргасан санал, гомдлын үр дүнд бодлого журмуудаа дахин хянах арга хэмжээ авах

Заримдаа болсон явдлыг бид өөрчлөх боломжгүй эсвэл санал, гомдлын менежер тухайн нөхцөлд анх гаргасан шийдвэр нь тохиромжтой байсан гэж үзэх тохиолдол байдаг. Ямар ч шийдвэр гаргасан санал, гомдлын менежер тухайн шийдвэрийн шалтгааныг танд тодорхой тайлбарлах болно. Энэ нь уулзалтаар, утсаар эсвэл имейлээр байж болно.

Хэрвээ та гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байвал санал, гомдлын менежертэй тухайн асуудлыг ярилцан, өөрийн бодлоо илэрхийлж болно.

Хэрвээ та санал нийлэхгүй хэвээрээ эсвэл тухайн санал, гомдлын шийдвэр буруу, санал гомдлыг шийдвэрлэх үйл явц шударга бус байсан гэж үзвэл дахин хянуулах хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг санал, гомдлын анх шийдвэрлэсэн менежер эсвэл түүнийг удирддаг хянах ажилтанд гаргах ёстой.

Дахин хянуулах хүсэлт гаргаж буй хүн ямар нэг байдлаар тухайн санал, гомдлын субъект хүн эсвэл санал, гомдлыг шийдвэрлэхэд оролцсон байж болохгүй.

Тухайн санал гомдлыг дахин хянахад NSW Ombudsman зэрэг гадны байгууллага оролцож болно.

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ танд илүү дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай утсаар холбогдоно уу. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Операторт залгахыг хүссэн дугаараа хэлэхэд оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.